



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81,
<http://www.mmhi.gov.mn>

2019. 03.29 № 01/853
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн
хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ,
үнэлгээний тайлан хүргүүлэх тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг тус тус удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр", Засгийн газрын 2016 оны 208 дугаар тогтоолоор баталсан "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний танилцуулгыг хавсралтуудын хамт хүргүүлж байна. Хөтөлбөрийн хэрэгжилт нь 2018 оны жилийн эцсийн байдлаар 55.7 хувьтай дүгнэгдсэн.

1. УУХҮЯ-ны Удирдлагын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээс 1 хуудас
2. Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний танилцуулга 4 хуудас
3. "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ, үнэлгээний нэгтгэл 2 хуудас
4. Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан (2018 оны жилийн эцсийн байдлаар) 15 хуудас
Хавсралт 2 хуудастай.



Д.СУМЪЯАБАЗАР



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2019 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Удирдлагын зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд:


ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны үйл ажиллагааны нэгдсэн тайлан;
2. Салбарт хэрэгжиж буй төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний танилцуулга
3. Алт-2 Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний танилцуулга
4. Гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний танилцуулга
5. Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн Б.Баяржаргал, Н.Баатар нар хийв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Яамны 2018 оны үйл ажиллагааны нэгдсэн тайланг хавсралтын хамт, салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан, Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан, Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг холбогдох журмын дагуу тогтоосон хугацаанд нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлэхээр шийдвэрлэв.

ДАРГА



Г.НАНДИНЖАРГАЛ

**ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**
/2018 оны жилийн эцсийн байдлаар/

2019 оны 03 дугаар сарын 18-ны өдөр

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”, Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 208 дугаар тогтоолоор баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээ тус бүрээр нь хяналтанд авч (Хавсралт 1), гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, шийдвэр гаргах түвшний удирдлагуудыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

“Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний “Макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг богино хугацаанд сайжруулах”, “Дунд хугацаанд эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийж, өрийн дарамтыг багасгах” 2 стратегийн 4 зорилт, 6 арга хэмжээ буюу нийт **24 арга хэмжээг** Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь хэрэгжүүлэхээр тусгагдсан. Эдгээрээс 17 арга хэмжээг дангаар, 3 арга хэмжээг толгойлон, 4 арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

“Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг тус тус удирдлага болгов.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1.5 дах заалтын дагуу нотлох баримтыг үндэслэж, мөн үндсэн чиглэлийн зорилтыг хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд гарах үр дүнг үнэлгээ хийх үед хүрсэн бодит үр дүнгийн түвшин, зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэлтэй харьцуулан, биелэлтийг хувиар тодорхойлж үнэлгээг өгсөн.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

“Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-т тусгагдсан Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны хэрэгжүүлэх 4 зорилт 24 арга хэмжээний биелэлт нь 2018 оны

жилийн эцсийн байдлаар **55.7** хувийн биелэлттэй, үүнээс 3 арга хэмжээ нь “үр дүнтэй” 100 хувь, 6 арга хэмжээ нь “тодорхой үр дүнд хүрсэн” 70 хувь, 14 арга хэмжээ нь “эрчимжүүлэх шаардлагатай” 40 хувийн хэрэгжилттэй, 1 арга хэмжээ “үнэлэх боломжгүй” байна.

Хөтөлбөрийн 1.1 дугаартай зорилт 70 хувь, 1.3 дугаартай зорилтын 1.3.1 арга хэмжээ 90 хувь, 1.3.8 дугаартай арга хэмжээ 49.4 хувь, 2.2 дугаартай зорилт 40 хувь, 2.3 дугаар зорилт 70 хувийн биелэлттэй дүгнэгдсэн (Хүснэгт 1).

“Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний хэрэгжилтэнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний нэгтгэл
(2018 оны жилийн эцсийн байдлаар)

Хүснэгт 1

Зорилтын дугаар	Арга хэмжээний дугаар	Арга хэмжээний тоо		Хэрэгжилтэнд өгсөн үнэлгээ (хувь)					Хэрэгжилт (хувь)
		АХ	НАХ	100	70	40	0	/-/	
СТРАТЕГИ 1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНЦВЭРТ БАЙДЛЫГ БОГИНО ХУГАЦААНД САЙЖРУУЛАХ									
Зорилт 1.1.	арга хэмжээ 1.1.7.	1	1	0	1	0	0	0	70.0
Зорилт 1.3.	арга хэмжээ 1.3.1.	3	3	2	1	0	0	0	90.0
	арга хэмжээ 1.3.8.	10	17	1	3	12	0	1	49.4
СТРАТЕГИ 2. ДУНД ХУГАЦААНД ЭДИЙН ЗАСАГТ БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ ХИЙЖ, ӨРИЙН ДАРАМТЫГ БАГАСГАХ									
Зорилт 2.2.	арга хэмжээ 2.2.1.	2	2	0	0	2	0	0	40.0
Зорилт 2.3.	арга хэмжээ 2.3.8.	1	1	0	1	0	0	0	70.0
Нийт дүн		17	24	2	5	14	2	1	55.7

Тайлбар: АХ-нарийвчилсан төлөвлөгөөний арга хэмжээ, НАХ- нарийвчилсан төлөвлөгөөний дэлгэрэнгүй арга хэмжээ, /-/үнэлэх боломжгүй

“Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай; шалгуур үзүүлэлттэй боловч гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй, гадаад хүчин зүйлээс шалтгаалсан дараахь 15 арга хэмжээ байна Үүнд:

“Эрчимжүүлэх шаардлагатай” 40 хувийн биелэлттэй 14 арга хэмжээ

- 1.3.8.2. Хар Овоогийн уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах
- 1.3.8.3. Ширэн Овоогийн төмрийн хүдрийн уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах
- 1.3.8.6. Цагаан суваргын зэс-молибдений уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах
- 1.3.8.8.2. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах хүрээнд: Боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолойн барилгын ажлын зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг эхлүүлэх
- 1.3.8.8.3. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах хүрээнд: Үйлдвэрийн барилга угсралт болон боловсон хүчнийг сургах ажлыг зохион байгуулах
- 1.3.8.9.1. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах хүрээнд: ТЭЗҮ-д шаардлагатай тодотгол хийх

7. 1.3.8.9.2. Төслийн хөрөнгө оруулагч болон төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах
8. 1.3.8.9.3. Шаардлагатай тусгай зөвшөөрлүүд, техникийн нөхцөлүүдийг авч бэлтгэл хангах
9. 1.3.8.9.4. Үйлдвэрийн дэд бүтэц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг эхлүүлэх
10. 1.3.8.10.1. Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулах хүрээнд: Нүүрсний нийлэг хийн үйлдвэрийн урьдчилсан болон нарийвчилсан ТЭЗҮ, БОННБҮ-г хүлээн авах
11. 1.3.8.10.2. Үйлдвэрийн дэд бүтэц, барилгын ажлыг эхлүүлэх
12. 1.3.8.10.3. Үйлдвэрийн барилга угсралт болон боловсон хүчнийг сургах ажлыг зохион байгуулах
- 13.2.2.1.1. Тавантолгойн ордод түшиглэн олборлон баяжуулах үйлдвэрийн цогцолборыг барьж байгуулах хэлэлцээрийг эцэслэн гэрээг байгуулж, хөрөнгө оруулалт орж эхлэх нөхцөлийг бүрдүүлэх
- 14.2.2.1.2. Гацууртын алтны үндсэн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах

“Үнэлэх боломжгүй” 1 арга хэмжээ

1. 1.3.8.4. Дулаан хар уулын холимог металлын уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжсэн “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн 4 зорилтын 24 арга хэмжээний биелэлт нь 2018 оны жилийн эцсийн байдлаар **55.7** хувьтай үнэлэгдэв.
2. Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлж, ойрын хугацаанд төлөх гадаад өр төлбөрийг санхүүжүүлэх үүсвэрийг шийдвэрлэх зорилтын хүрээнд Алт хөтөлбөрийг шинэчлэн үргэлжлүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангалттай сайн гүйцэтгэн ажилласан.
3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах хоолойн барилгын ажлын зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг эхлүүлэх, уулын баяжуулах үйлдвэрүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах буюу хүнд үйлдвэрийг барьж байгуулах, бүтээн байгуулалтын ажлыг бодитоор эхлүүлэх ажлууд удаашралтай хэрэгжиж байна.
4. Хөтөлбөрт тусгагдсан бусад байгууллагуудтай тус яамны “хамтран” хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг хариуцсан нэгж, албан хаагчид хяналтандаа авч, хэрэгжилтийн үр дүнг тайлагнах талаар анхаарахгүй, орхигдуулсан.
5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөнд тусгагдсан шаардагдах хөрөнгөний талаар биелэлтэндээ дурдаагүй, хүрсэн үр дүнг шалгуур үзүүлэлттэй холбон тайлагнах талаар хангалтгүй ажиллаж байна.
6. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны асуудал хариуцсан мэргэжлийн нэгжүүд болон нийтлэг чиг үүрэгтэй төрийн захиргааны удирдлагын нэгжийн албан хаагчид нь хариуцсан асуудлаар боловсруулсан бодлого, төлөвлөлтийг холбогдох бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах, хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хяналтандаа авах, хэрэгжилтийн үр дүнд анхаарах, биелэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоосон хугацаанд товч тодорхой тайлагнах, дэлгэрэнгүй тайланг танилцуулга хэлбэрээр, холбогдох нотлох

баримтуудын хамт хавсаргах талаар хариуцлагатай, санаачлагатай ажиллахгүй байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны асуудал хариуцсан мэргэжлийн нэгжийн удирдлага, албан хаагчид нь чиг үүрэг, хариуцсан асуудлаар боловсруулж байгаа бодлого, төлөвлөлт болон бодлогын баримт бичгийн биелэлтийг тайлагнахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна.
2. Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт тусгагдсан 24 арга хэмжээний эрчимжүүлэх шаардлагатай 14 арга хэмжээ, үнэлэх боломжгүй 1 арга хэмжээний хэрэгжилтэнд анхаарч, бодитой үр дүнд хүргэхэд чиглэн ажиллах шаардлагатай байна.

Хавсралт:


1. "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ, үнэлгээний нэгтгэл, 2 хуудас,
2. Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан (2018 оны жилийн эцсийн байдлаар), 15 хуудас,
Нийт 17 хуудас.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

2019 оны 03 дугаар сарын 28-ны өдөр

Хянасан:

ХШҮДАГ-ын дарга



Г.Ганхүү

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж,
танилцуулга боловсруулсан:

ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн

Н.Баатар /2019.03.28/



"Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөнд
тусгагдсан зорилт, арга хэмжээ, үнэлгээний нэгтгэл
(2018 оны жилийн эцсийн байдлаар)

2019 оны 03 дугаар сарын 28-ны өдөр

дд	Зорилт	Арга хэмжээ	Үнэлгээ /хувь/
1	1.1. Улсын төсвийн алдагдлыг бууруулж, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.	1.1.7. Хөрөнгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, олон нийтийн оролцоог хангах эрх зүйн орчныг сайжруулах. 1.1.7. Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д заасны дагуу стратегийн орд газар эзэмшиж байгаа хуулийн этгээдийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах ажиллагааг эрчимжүүлэх	70
2	1.3. Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлж, ойрын хугацаанд төлөх гадаад өр төлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэрийг шийдвэрлэх	1.3.1. Алт хөтөлбөрийг шинэчлэн үргэлжлүүлэх. 1.3.1.1. "Алт" хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх	100
3		1.3.1. 2. Хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх	70
4		1.3.1. 3. Алтны нөөцийг тогтвортой өсгөх, олборлолт, үйлдвэрлэлийг эрчимжүүлэх	100
5		1.3.8. Техник, эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн, хөрөнгө оруулагч нь тодорхой болсон бэлэн төслүүдийг бүх талаар дэмжиж, хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.3.8.1. Улааны холимог металлын уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах	100
6		1.3.8.2. Хар Овоогийн уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах	40
7		1.3.8.3. Ширэн Овоогийн төмрийн хүдрийн уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах	40
8		1.3.8.4. Дулаан хар уулын холимог металлын уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах	/-/
9		1.3.8.5. Цахиурт Овоогийн төмрийн хүдрийн уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах	70
10		1.3.8.6. Цагаан суваргын зэс-молибдений уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах	40
11		1.3.8.7. Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх	70
12		1.3.8.8. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах 1.3.8.8.1. Үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд:	40
13		1.3.8.8.2. Боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолойн барилгын ажлын зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг эхлүүлэх	40
14		1.3.8.8.3. Үйлдвэрийн барилга угсралт болон боловсон хүчнийг сургах ажлыг зохион байгуулах	40

15		1.3.8.9. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах хүрээнд: 1.3.8.9.1. ТЭЗҮ-д шаардлагатай тодогтол хийх	40
16		1.3.8.9.2. Төслийн хөрөнгө оруулагч болон төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах	40
17		1.3.8.9.3. Шаардлагатай тусгай зөвшөөрлүүд, техникийн нөхцөлүүдийг авч бэлтгэл хангах	40
18		1.3.8.9.4. Үйлдвэрийн дэд бүтэц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг эхлүүлэх	40
19		1.3.8.10. Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулах хүрээнд: 1.3.8.10.1.Нүүрсний нийлэг хийн үйлдвэрийн урьдчилсан болон нарийвчилсан ТЭЗҮ, БОННБҮ-г хүлээн авах	40
20		1.3.8.10.2. Үйлдвэрийн дэд бүтэц, барилгын ажлыг эхлүүлэх	40
21		1.3.8.10.3. Үйлдвэрийн барилга угсралт болон боловсон хүчнийг сургах ажлыг зохион байгуулах	
22	2.2. Бодит салбарын өсөлтийг дэмжих томоохон төслүүдийг эхлүүлж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	2.2.1. Таван толгойн бүлэг ордыг ашиглах, Таван толгойн 450 МВт-ын цахилгаан станц, Гацууртын алтны орд, Дулааны III цахилгаан станцын 250 МВт-ын өргөтгөл, Чойбалсангийн ДЦС-ын 50 МВт-ын өргөтгөл зэрэг төслүүдийг хэрэгжүүлэх. 2.2.1.1. Тавантолгойн ордод түшиглэн олборлон баяжуулах үйлдвэрийн цогцолборыг барьж байгуулах хэлэлцээрийг эцэслэн гэрээг байгуулж, хөрөнгө оруулалт орж эхлэх нөхцөлийг бүрдүүлэх	40
23		2.2.1.2. Гацууртын алтны үндсэн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах	40
24	2.3. Эдийн засгийн өсөлтийг дэмжих хариуцлагатай засаглалыг бэхжүүлж, хууль эрх зүйн тогтвортой орчныг бүрдүүлэх	2.3.8. Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг мэргэшсэн, хариуцлагатай, цомхон, тогтвортой байх эрх зүйн орчныг бүрдүүлэх. 2.3.8.2. Чиг үүргийн шинжилгээнд үндэслэн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах	70
24	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ		55.7

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Хянасан: ХШҮДАГ-ын дарга

Ганхүү

Үнэлгээний нэгтгэлийг хийсэн:

ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн

Н. Баатар /2019.03.28/

ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
(2018 оны жилийн эцсийн байдлаар)

2019 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

№	Хөтөлбөр/төслийн агуулга		Гүйцэтгэл								
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).		“Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”, УИХ, 2016.11.24, №71,								
			“Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөөө, ЗГ, 2016.12.28, №208								
			Хөтөлбөрийн зорилго: Эдийн засгийн сэргээх								
2	Санхүүжилтийн эх үүсвэр		Улсын төсөв, гадаад эх үүсвэр, хувийн хэвшил								
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа		Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ								
			Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: СЗХ, ТӨБЗГ, СЯ, БОАЖЯ, Монгол банк, ЗГХЭГ, ЗТХЯ, ЭХЯ, ТАЗ								
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		Зорилт 1.1. Улсын төсвийн алдагдлыг бууруулж, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.								
			Зорилт 1.3. Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлж, ойрын хугацаанд төлөх гадаад ер төлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэрийг шийдвэрлэх								
			Зорилт 2.2. Бодит салбарын өсөлтийг дэмжих томоохон төслүүдийг эхлүүлж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх								
			Зорилт 2.3. Эдийн засгийн өсөлтийг дэмжих хариуцлагатай засаглалыг бэхжүүлж, хууль эрх зүйн тогтвортой орчныг бүрдүүлэх								
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)									
			Үүнд:	Гүйцэтгэл					Хувь		
			Багц 1								
			Багц 2 (г.м)								
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:		Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.								

<p>1.1-р зорилтын хүрээнд: 1.1.7. Хөрөнгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, олон нийтийн оронцог хангах эрх зүйн орчныг сайжруулах.</p> <p>1.1.7.5: Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д заасны дагуу стратегийн орд газар эзэмшиж байгаа хуулийн этгээдийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах ажиллагааг эрчимжүүлэх</p>	<p>“Эрдэнэс Тавантолгой” ХК, “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Нарийнсухайтын авто зам” ХХК-иудыг нэгтгэн корпорацийн зохион байгуулалтаар ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын тогтоолын үр дүнд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн мэдлийн хувьцааг эзэмших, үйл ажиллагааг нь нэгтгэн удирдах эрх зүйн чадамж баталгаажиж охин болон хараат компаниудад засаглалын зохистой зарчмуудыг хэрэгжүүлэх, арилжааны зарчмаар ашгийн төлөө ажиллах нөхцлөөр хангах, бизнесийн удирдлагын дэвшилтэт арга ажиллагааг нэвтрүүлэх замаар дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай үндэсний компаниудыг бий болгож, хувьцаа эзэмшигчдийн хүртэх үр өгөөжийг дээшлүүлэх зорилттой ажиллаж байна. Засгийн газрын 2017 оны 154 дугаар “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Сангийн яам, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн бүртгэл дэх хувьцаа эзэмшигчийн мэдээллийг тулгаж бүртгэсэн дүнгээр нийт 486 аж ахуйн нэгж 7,065,038 ширхэг хувьцаа буюу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны 0.05 хувийг эзэмшиж байна.</p> <p>“Эрдэнэс-Тавантолгой” ХК байгуулагдсан цагаас хойш нийтдээ 192.2 сая м3 хөрс хуулалтын ажил гүйцэтгэж, нийт 45.92 сая тонн нүүрс олборлосон бөгөөд үүнээс 2018 онд нийт 11.0 сая тонн нүүрс олборлож, 13.1 сая тонн нүүрс борлуулсан байна.</p> <p>Ийнхүү үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдсэнээр 2018 оны аудитлагдаагүй тайлангаар борлуулалтын орлогын хэмжээ 1,986.9 тэрбум төгрөгт, улсын төсөвт татвар, хураамж хэлбэрээр нийт 484.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, татварын дараах цэвэр ашиг 801.1 тэрбум төгрөгт хүрсэн. Дээрх үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал борлуулалтын орлогын хэмжээ 804.5 тэрбум буюу 68 хувиар, цэвэр ашгийн хэмжээ 340 тэрбум төгрөг буюу 74 хувиар тус тус өссөн байна.</p> <p>Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8 дах хэсэгт “Ногдол ашгийг компанийн татвар төлсөний дараах цэвэр ашгаас хуваарилна” гэж, Санхүүгийн зохицуулах хорооны 2007.12.26-ны өдрийн 210 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ын 8 дугаар зүйлийн 8.1.3 дах заалтад “Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлэх ёстой бөгөөд уг мэдээлэл нь ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн ойлголт өгөхүйц байх ёстой.” гэж тус тус тусгагдсан байхын зэрэгцээ тус кодекст “Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилж байх нь зүйтэй” гэж тайлбарласан байдаг. Энэ хүрээнд “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019.02.18-ны өдрийн хурлаар ногдол ашиг хуваарилах асуудлыг хэлэлцээд нэгж хувьцаанд 25 төгрөгийн ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 03 дугаар тогтоолыг батлуулж, хэрэгжилтийг хангахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Тодорхой үр дүнд хүрсэн 70%</p>
--	---

<p>1.3-р зорилтын хүрээнд: 1.3.1. Алт хөтөлбөрийг шинэчлэн үргэлжлүүлэх. 1.3.1.1. "Алт" хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх</p>	<p>"Алт-2" үндэсний хөтөлбөрийг 2017 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Уг хөтөлбөр нь УИХ-аас батлан гаргасан "Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичиг"-т тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх бодлогын хүрээнд Алт үйлдвэрлэлийн салбарын ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг бий болгоход чиглэгдсэн зорилтот анхдагч баримт бичиг болсон. Хөтөлбөрт төлөвлөгдсөн нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэхээр ЗГХЭГ, УУХҮЯ, СЯ, БОАЖЯ, Монгол банк, орон нутгийн захиргаанууд, ЦЕГ, мэргэжлийн бусад төрийн болон төрийн бус байгууллагууд, алт олборлогч аж ахуйн нэгжүүд хамтран ажиллав. Эдгээр байгууллагуудын хамтын ажиллагаа, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд 2017 оны гүйцэтгэлээр хөтөлбөрийн үндсэн үзүүлэлтийн алт олборлолтын төлөвлөгөөг 2.0 тонноор давуулж, Монгол банканд тушаагдсан алтны хэмжээ 20 тоннд хүрч, Монгол Улсад 700.0 гаруй сая долларын валютын эх үүсвэрийг бүрдүүлсэн.</p> <p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн захирамжаар "Алт-2" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын ажиллагаатай орон тооны бус Зөвлөлийг байгуулж ажилласан нь хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад холбогдох байгууллагуудын хамтын оролцоог бэхжүүлж, алт тушаалтыг нэмэгдүүлэх компани ажлууд хийгдэж эхэлсэн. Үр дүнтэй 100 %</p>
<p>1.3.1.2 Хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх</p>	<p>1/ 2018 оны 3 дугаар сарын 2-ны өдөр "Алтны салбарын уулзалт" хэлэлцүүлгийг зохион байгуулж, алтны салбарын тулгамдсан асуудлаар УУХҮ-ийн сайд, салбарын төрийн болон төрийн бус байгууллага, алт үйлдвэрлэгчдийн холбоо, алт олборлогч ААН-ийн төлөөллүүд санал солилцсон. 2/ "Mongolia Gold-2018" чуулганыг 2018 оны 03 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж, алтны салбарын хууль эрх зүй, татварын болон хөрөнгө оруулалтын орчинг тогтвортой байлгах, хуулийн нэмэлт өөрчлөлтүүдээс үүдэн бий болсон аж ахуйн нэгжүүдэд учирч буй эдийн засгийн болон бусад хохирлуудыг шийдвэрлэх, бэлтгэгдсэн нөөцүүдийг эргэлтэд оруулах зэрэг салбарт тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэв. Хурлаар алтны салбарт тулгарч буй саад бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцэж, Монголын алт үйлдвэрлэгчдийн холбооноос төрийн байгууллагууд, орон нутгийн ИТХ-ийн төлөөлөгч нартай болон Хятад улсын Алтны холбоотой хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулав. Алтны татварын эрх зүйн орчинг тогтвортой байлгах үүднээс Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, урьдчилсан тандан судалгааны хамтаар боловсруулж, Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 45 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжигдсэн.</p>

		<p>Хуулийн төслийг 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн УИХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан боловч чуулганы ирц бүрэлдээгүйн улмаас дараагийн хурал хуралдах хүртэл хүлээгдсэн. Алт олборлогч ААН-үүдийн уулын ажлын тайг ангийн гүйцэтгэл, 2018 оны батлагдсан уулын ажлын төлөвлөгөө, ТЭЗҮ-д үндэслэсэн 114 ААН-ийн санхүүжилтийн судалгааг гаргасан. Татварын багц хуулинд алтны АМНАТ-ын хэмжээг тогтвортой байлгах талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллаж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/47 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Нэг цэгийн үйлчилгээний төвийг бичил уурхай төвлөрсөн орон нутагт байгуулж, алт сорьцлох, худалдан авах төвлөрлийг сааруулах, холбогдох дүрэм журмын өөрчлөлтийг боловсруулан мөрдүүлэх талаар ажилласан. Хөгжлийн банк, Монгол банкны удирдлагуудтай алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар уулзалтыг зохион байгуулж санал солилцсон. "Алт-2" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийтдээ алтны 26 төсөлд 53.273 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн бөгөөд нэмж 43.821 тэрбум төгрөг олгох үлдэгдэлтэй байна. 2018 онд сонгон шалгаруулалтаар хайгуулын 27 тусгай зөвшөөрөл олгогдож улсын төсөвт 13.8 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.</p> <p style="text-align: right;">Тодорхой үр дүнд хүрсэн 70%</p>
	<p>1.3.1.3. Алтны нөөцийг тогтвортой өсгөх, олборлолт, үйлдвэрлэлийг эрчимжүүлэх</p>	<p>Хөтөлбөрийн хүрээнд 2017 онд 18.0 тонн алт олборлохоос 20.01 тонн алт олборлож байсан бол 2018 онд 21.0 тонн алт олборлохоор төлөвлөснөөс Монгол банканд 21.9 тонн алт тушаагдаж төлөвлөгөө зорилтоо амжилттай биелүүлээд байна. Тайлант хугацаанд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 15 удаагийн хуралдаанаар алтны 42 шороон орд, 5 үндсэн ордын хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэж, нийт 23.2 тн алтны нөөцийг хүлээн авсан байна. УУХҮЯ-2017/7 тоот гэрээний дагуу Монгол орны төв болон зүүн бүсийн нутагт хийж гүйцэтгэсэн алтны сэдэвчилсэн судалгааны завсрын ажлын тайланг гаргаж, 2018 онд гүйцэтгэх төслийн ажлын төсвийн тодотголыг хэлэлцүүлсэн байна. Монгол орны Төв болон Зүүн бүсийн алтны сэдэвчилсэн судалгааны ажил нь Монгол орны газар нутгийн 1/3 орчим талбайд тархсан алтны орд, илрэлүүдийн байршлын зүй тогтлыг тогтоох чиглэлээр 1930-аад оноос эхлэн гүйцэтгэсэн судалгааны ажлуудын үр дүнг нэгтгэн дүгнэх, хээрийн шалгалтын ажлаар судлах замаар тухайн талбайн алтны хүдэржилтийн тархалтын зүй тогтлыг шинжлэх ухааны орчин үеийн түвшинд ангилж, улмаар хэтийн төлөв бүхий талбай, орд газруудыг илрүүлэн үнэлэлт, дүгнэлт өгөх зорилготой ажил юм. Маршрутын судалгааны ажлаар 79 хэтийн төлөв бүхий талбайн жагсаалтыг гарган сорьцлолтыг ажлыг хийж шинжилгээнд хамруулан хэд хэдэн сонирхол татахуйц эрдэсжсэн цэг, илрэл, хувирлын бүсүүдийг тогтоосон байна. Тухайлбал: шинээр тогтоогдсон Бага уулын алт, зэсийн хувирлын бүс. Уг төслийн хээрийн ажлын гүйцэтгэлийн үйл ажиллагаанд шуурхай хяналтыг УУХҮЯ, АМГТГ-аас явуулсан.</p>

		<p>УУХҮ-ийн сайдын 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн А/28 дугаар тушаалаар "Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам"-д "Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл/ЭБМЗ/"-ийн "Дүрэм аргачлал батлах" тухай УУХҮ-ийн сайдын 2018 оны 2 дугаар сарын 26-ны А/46 тоот тушаалаар тус тус дүрэмд холбогдох өөрчлөлт оруулж ЭБМЗ-ийг шинээр байгуулснаар ордын нөөцийг бүртгэж эхэлсэн. "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030", "Алт 2" хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит "Эрдэнэс Монгол" компанийн 100%-ийн эзэмшлийн "Эрдэнэс алт ресурс" компанийг байгуулсан. "Алт-2" үндэсний хөтөлбөрийн хүрээнд алт олборлолтыг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкнаас санаачлан Монгол Улсын хэмжээнд "Эх орныхоо алтыг эрдэнэсийн сандаа" аяныг 5 сарын хугацаанд амжилттай зохион байгуулж алт тушаалтын хэмжээг 1.9 тн -оор нэмэгдүүлсэн. Энэ ажлын хүрээнд Дархан-Уул, Баянхонгор аймагт алт худалдан авах, сорьц тогтоох нэг цэгийн төвийг 265.0 сая төгрөгөөр байгуулж, орон нутагт алт худалдаж авч эхэлснээр "Алт-2" үндэсний хөтөлбөрийн 1.11-д тусгасан зорилт биелж байна.</p> <p>Үр дүнтэй 100 %</p>
1.3.8. Техник, эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн, хөрөнгө оруулагч нь тодорхой болсон бэлэн төслүүдийг бүх талаар дэмжиж, хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.3.8.1. Улааны холимог металлын уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах		<p>Улааны холимог металлын уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах Улсын комисс 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр ажиллан, үйл ажиллагааг эхлүүлж, ашиглалтад хүлээн авсан.</p> <p>Улааны холимог металлын уулын баяжуулах үйлдвэр нь 2018 оны жилийн эцсийн байдлаар 664.82 мянган тонн хүдэр олборлож, 670.05 мянган тонн хүдэр боловсруулж, 65.73 хувийн агуулгатай хар тугалганы баяжмал 20,002.31 тонн, 47.19 хувийн агуулгатай цайрын баяжмал 25,432.73 тонныг үйлдвэрлэн нийт хар тугалганы баяжмал 22,616.11 тонныг, цайрын баяжмал 27,626.23 тонныг тус тус экспортлосон байна. Төслийн ажил хэвийн үргэлжилж байна. Улааны холимог металлын уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулснаар нийт 500 ажлын байр бий болж улмаар улс орон нутгийн төсөвт 39 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. Үр дүнтэй 100 %</p>
1.3.8.2. Хар Овоогийн уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах		<p>Хар овоогийн холимог металлын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотголыг шинэчлэн боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтээ Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас гаргуулсан. Тус ордын байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ нь батлагдаагүй.</p> <p>Эрчимжүүлэх шаардлагатай 40 %</p>
1.3.8.3. Ширэн Овоогийн төмрийн хүдрийн уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах		<p>Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт заасан уурхай, уулын үйлдвэрийн байнгын ашиглалтад оруулах Улсын комисс 2017 оны 7 дугаар сард уурхай, уулын үйлдвэр дээр ажиллан, үйл ажиллагааг эхлүүлж, ашиглалтад оруулсан. "Зэст Өндөр" ХХК-ийн зүгээс төслийн үйл ажиллагааг эхлүүлэхэд зайлшгүй шаардлагатай байгаа бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам, гүүрний ажил, гаалийн хяналтын талбай барьж байгуулах, эрчим хүчний шугам татах зэрэг анхны хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг хүссэн хүсэлтээ Хөгжлийн банканд хүргүүлсэн. "Зэст Өндөр" ХХК-ийн хүсэлтийг харгалзан үзээд Хөгжлийн банкнаас 439.5 сая иен, 10.0 тэрбум төгрөгний зээл олгосон ба тус компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж эхлээд байна. Ширэн Овоогийн төмрийн хүдрийн ил уурхай, баяжуулах үйлдвэр ашиглалтад орсноор нийт 800 ажлын байр бий болсон. Мөн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам, гүүрны ажил, гаалийн хяналтын талбай зэргийг барьж байна.</p> <p>Эрчимжүүлэх шаардлагатай 40 %</p>

<p>1.3.8.4. Дулаан хар уулын холимог металлын уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах</p>	<p>Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт орших Дулаан хар уулын холимог металлын далд уурхай, баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөл эзэмшигч "Юүмингшинг" ХХК-ийн удирдлагатай УУХҮЯ-ны төлөөлөл уулзалт зохион байгуулж, тус төслийн өнөөгийн байдал, явцын талаар танилцаж, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөлдөв. Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт орших Дулаан хар уулын холимог металлын далд уурхай, баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөл эзэмшигч "Юүмингшинг" ХХК - нь санхүүгийн хүндрэлтэй байдалд орсон шалтгаанаар үйл ажиллагаагаа зогсоогоод байна. Үнэлэх</p> <p>боломжгүй /-/</p>
<p>1.3.8.5. Цахиурт Овоогийн төмрийн хүдрийн уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах</p>	<p>Цахиурт Овоогийн төмрийн хүдрийн ил уурхай, баяжуулах үйлдвэр нь үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба Сүхбаатар аймгийн төв болон Уулбаян сумаас үйлдвэрт ажиллах ажилчдаа авч дадлагажуулах, мэргэшүүлэх ажлыг хийж байна. "Эм Эл Цахиурт Овоо" ХХК нь үйл ажиллагаагаа эхлүүлснээр 2017 оны байдлаар 262.7 мянган тонн хүдэр олборлон 99.54 мянган тонн баяжмал үйлдвэрлэж 64.9 хувийн агуулгатай 50.0 мянган тонн төмрийн нойтон баяжмал экспортлосон, 2018 оны эхний хагас жилийн байдлаар 59,405.18 тонн төмрийн хүдэр олборлон 48,650.82 тонн төмрийн хүдэр худалдан авч 31,803 тонн баяжмал үйлдвэрлэн 35,469.39 тонныг экспортлосон байна. 2018 оны 3 дугаар улирлаас үйл ажиллагаагаа зогсоож, ордынхоо нөөцөд тулгуурлан металлургийн үйлдвэрлэлийг байгуулах судалгааг хийж байна. Мөн ордыг бүрэн ашиглах зорилгоор гантиг чулууны нөөцийг тооцож, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, улмаар гантиг чулууны ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулаад байна. Цахиурт Овоогийн төмрийн хүдрийн ил уурхай, баяжуулах үйлдвэр ашиглалтад орсноор нийт 120 ажлын байр бий болсон. <i>Мөн бүтээгдэхүүнийг Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Бичигтийн боомтын авто замаар тээвэрлэн экспортлох замын маршрутын асуудлыг шийдвэрлэх, цахилгаан хангамжийг тогтвортой байлгаж, үйлдвэрийг бүрэн хүчин чадлаар хэвийн ажиллагааг хангах асуудлыг шийдвэрлэх. Тодорхой үр дүнд хүрсэн 70%</i></p>

<p>1.3.8.6. Цагаан суваргын зэс-молибдений уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах</p>	<p>“Монголын алт (МАК)” ХХК нь Цагаан-Суваргын зэс-молибдены ордын зэсийн исэлдсэн хүдрийн нөөцийн тодотголыг хийж улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2017 оны 2 сард хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. Мөн төслийн хүрээнд Цагаан суваргын зэс-молибдений ордын исэлдсэн хүдрийг боловсруулах жилд 5000 тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн. Цагаан суваргын зэс-молибдений ордын бүтээн байгуулалтад Ил уурхайн тоног төхөөрөмжүүдийн худалдан авалт бүрэн хийгдэж, төслийн талбайд угсран байргуулж, олборлолтын ажлыг эхлүүлэхэд бэлэн болгоод байна. 20.0 сая долларын үнэ бүхий тоног төхөөрөмжүүд АНУ, Европын холбоо, Австрали зэрэг улсуудад 2014 онд үйлдвэрлэгдэж дууссан. Зарим тоног төхөөрөмжийг төслийн талбайд авчирсан бөгөөд дийлэнх хэсэг нь (90%) АНУ -ын Солт Лэйк, Швейцарийн Швейцарийн Цюрих хотуудад 3 дахь жилдээ түрээсийн агуулахуудад өндөр төлбөртөй (1-2 сая доллар жил тутам төлж байгаа) хадгалагдаж байна. Тоног төхөөрөмжийн үлдэгдэл төлбөр болон тээврийн зардлыг (60 сая ам.доллар) доллар) төлмөгц тухайн тоног төхөөрөмжийг татан татан авчирч, угсарч суурилуулсанаар 2018 оны оны 2 дугаар хагаст үйлдвэрийг ашиглалтад авах боломжтой. Оюутолгой -Цагаансуваргын чиглэлийн 220 кв -ийн ЦДАШ, дэд станцын барилга угсралтын ажлын гүйцэтгэл – 50 %. Төслийн бүтээн байгуулалт: Анхан шатны бутлуур, бутлагдсан хүдрийн агуулахын суурь, хагас өөрөө нунтаглалтын тээрмийн суурь, баяжуулах, усгүйжүүлэх хэсгийн суурь, хүчитгэсэн хана угсралтын ажил болон оффис, ажилчдын тосгон зэргийг барьж байгуулаад байна. Эрчимжүүлэх шаардлагатай 40 %</p>
<p>1.3.8.7. Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх</p>	<p>2018 оны төсвийн тухай хуулиар 2018 онд 8.1 сая баррель /1.1 сая тонн/ газрын тос олборлон экспортолж, борлуулалтын орлогоос улсын төсөвт 223.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан. 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 6.4 сая баррель / 866.3 мянган тонн/ газрын тос олборлон 6.18 сая баррель /840.4 мянган тонн/ газрын тос экспортолж улсын төсөвт 2018 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 223.4 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төсвийн орлого төвлөрүүлэлт 99.6%-ийн гүйцэтгэлтэй байна. Тодорхой үр дүнд хүрсэн 70%</p>

<p>1.3.8.8. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах хүрээнд: 1.3.8.8.1. Үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг хангах</p>	<p>Төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн эцсийн тайланг Энэтхэгийн тал 2018 оны 07 дугаар сард ирүүлсэнтэй холбогдуулан үйлдвэрийн технологийн сонголт, төсөвт өртгийн тооцоолол зэрэг хэд хэдэн асуудлуудаар Захиалагчийн зүгээс тодруулга хийх нь зүйтэй гэж үзэн хоёр улсын энэхүү төслийг хариуцан ажиллаж буй төрийн болон хувийн хэвшлийн төлөөлөгчид оролцсон техникийн зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатар хотноо 2018 оны 09 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулж, Монголын талаас Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Гадаад хэргийн яам, төсөл хэрэгжүүлэгч "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК, Энэтхэгийн талаас Гадаад хэргийн яам, Сангийн яам, Эксим банк болон төслийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулсан "Инженерс Индиа Лимитед" компанийн төлөөлөгчид оролцсон. Энэхүү уулзалтаар төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн тайланд тусгагдсан "технологийн процесс, төслийн төсөвт өртгийн тооцоолол болон түүнийг хэрхэн бууруулах, төслийн менежментийн зөвлөхийг сонгон шалгаруулах, төслийн арга хэмжээний хамтарсан төлөвлөгөөг батлах, боловсруулах үйлдвэрт мэргэжилтэн бэлтгэх, төслийн менежментийн зөвлөхийн төлөөлөгчийн газрыг Улаанбаатар хотод байгуулах, нарийвчилсан ТЭЗҮ-г хүлээн авах" зэрэг хэд хэдэн асуудлыг хэлэлцэж талууд хурлын тэмдэглэл үйлдэж баталгаажуулав. Захиалагч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, төсөл хэрэгжүүлэгч "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК компани болон захиалагчийн инженер Итали Улсын "КТ-Кинетикс" компанийн зүгээс нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлийн ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажилласан бөгөөд эцсийн тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2018.11.15-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэн дүгнэлт гаргуулж, хүлээн авахаар шийдвэрлэсэн.</p> <p style="text-align: right;">Тодорхой үр дүнд хүрсэн 70%</p>
<p>1.3.8.8.2. Боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолойн барилгын ажлын зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг эхлүүлэх</p>	<p>Монгол Улсын Загсийн газрын зүгээс төслийн хэрэгжилтийг түргэн шуурхай зохион байгуулах үүднээс газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах талбайгаас төвийн дэд бүтэцтэй холбогдох "Сайншанд-Алтанширээ" чиглэлийн 27 км урт салаа төмөр зам, 18,2 км урт цахилгаан хангамжийн 110 Кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 110/10 Кв-ын 6.3 МВА-ын суурилагдсан хүчин чадал бүхий дэд станц болон 16,63 км урт хатуу хучилттай авто зам барих ажлуудыг 2018 оны 06 дугаар сараас эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд дээрх төслүүдийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 40% орчим хувьтай явж байгаа бөгөөд 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.</p> <p>Энэхүү ажлын хүрээнд УУХҮСайд 2018 оны 9 дүгээр сарын 23-наас 25-ны өдрүүдэд ОХУ-д албан айлчлал хийж "Роснефть" компанийн гүйцэтгэх захирал И.И.Сечинтэй уулзаж Төрөөс Газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын хүрээнд хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлон хамтран ажиллаж байна. Мөн энэхүү уулзалтаар Монгол Улсад "газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолойн төсөл"-ийг МУ-ын Засгийн газрын зүгээс хэрэгжүүлж байгаатай холбогдуулан түүхий тос дамжуулах хоолойн технологийг судлах, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх түүний бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилтийн боломжит эх үүсвэрийг тодорхойлох чиглэлээр санал солилцсон бөгөөд уулзалтын мөрөөр "Роснефть" компанийн төлөөлөгчид 2018 оны 09 дүгээр сарын 26-наас 10 дугаар сарын 03-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо албан айлчлал хийж энэхүү төслийн талаар холбогдох байгууллага, төлөөлөгчидтэй уулзаж санал солилцож цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлсон</p> <p style="text-align: right;">Эрчимжүүлэх шаардлагатай 40 %</p>

<p>1.3.8.8.3. Үйлдвэрийн барилга угсралт болон боловсон хүчнийг сургах ажлыг зохион байгуулах</p>	<p>БНЭУ-ын Гадаад хэргийн яам, Экспорт-Импорт банк болон газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж буй Зөвлөх "Инженерс Индиа Лимитед" компанийн төлөөлч нартай 2018 оны 09 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулсан уулзалтаас гарсан хурлын тэмдэглэлд боловсруулах үйлдвэрт ажиллах боловсон хүчний жагсаалтыг дэлгэрэнгүй гаргаж өгөхөөр тохиролцсон ба Энэтхэгийн талаас Техник, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрт тусгах талаар санал гаргасан. Энэхүү ажлыг Монгол Улсаас Энэтхэг Улсад суугаа элчин сайдын яам болон Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа элчин сайдын яамдаар дамжуулан хэрэгжүүлэхээр тохиролцоод байна.</p> <p>Засгийн газрын 2018.10.24-ний өдрийн "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 323 дугаар тогтоолоор "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн төслийн менежментийн зөвлөх компанийг сонгох ажлыг эрчимжүүлж шуурхай зохион байгуулах үүргийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад даалгасан.</p> <p>Дээрх тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн төслийн менежментийн компанийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг, ажлын даалгаврыг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-тай хамтран монгол, англи хэл дээр боловсруулаад байна. БНЭУ-ын Эксим банк 2018 оны 10 дугаар сард Монгол Улсад хэрэгжих "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн төслийн менежментийн зөвлөхийг сонгон шалгаруулах урьдчилсан тендерийг хоёр улсын хооронд байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд тус банкны журмын дагуу Энэтхэгийн Зөвлөх компаниудын дунд зарласан бөгөөд энэхүү тендерийн урьдчилсан сонгон шалгаруулалтын дүнг 2018.12.04-ний өдрийн "GOILOC-258/18-19/2107" тоот албан бичгээр ирүүлээд байна.</p> <p>Эрчимжүүлэх шаардлагатай 40 %</p>
<p>1.3.8.9. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах хүрээнд: 1.3.8.9.1. ТЭЗҮ-д шаардлагатай тодотгол хийх</p>	<p>УУХҮЯ-ны дэргэдэх "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл" хэрэгжүүлэх нэгж Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, 2018 оны 08 сарын 14-ний өдөр УУХҮЯ-ны дэргэдэх "Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл"-өөр хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсан. "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн Байгаль орчны ерөнхий үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэж 2018 оны 05 сарын 20-нд хүлээн авсан бөгөөд тайланг БОАЖЯ хянан үзэж, дүгнэлтийг 2018 оны 11 сарын 27-ны өдрийн 13/8361 тоот албан бичгээр ирүүлээд байна. Эрчимжүүлэх шаардлагатай 40 %</p>
<p>1.3.8.9.2. Төслийн хөрөнгө оруулагч болон төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах</p>	<p>"Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, уг төслийг хэрэгжүүлэгч нэгжид дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад хууль, санхүүгийн гадаад, дотоодын зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг 2018 оны 08-10 сард зохион байгуулж, төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах хууль, санхүүгийн зөвлөх үйлчилгээний гэрээг "Өмгөөллийн Монгол өмгөөлөгч" ХХН-тэй байгуулан, тайланг гэрээний дагуу хүлээн авсан. Эрчимжүүлэх шаардлагатай 40 %</p>
<p>1.3.8.9.3. Шаардлага тай тусгай зөвшөөрлүүд, техник ийн нөхцөлүүдийг авч бэлтгэл хангах</p>	<p>"Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн захиалгаар Швейцарийн "Айд процесс стратеги" ХХК-аар хүхрийн хүчлийг ашиглан фторл устөрөгч, фторт хөнгөн цагаан үйлдвэрлэх урьдчилсан судалгааг хийлгэсэн. Эрчимжүүлэх шаардлагатай 40 %</p>

<p>1.3.8.9.4. Үйлдвэрийн дэд бүтэц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг эхлүүлэх</p>	<p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт орших 466.0 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх зориулалтаар "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" тогтоолын төслийг боловсруулж Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын яам нь тогтоолын төсөлд яамдаас санал авч, 2018 оны 12 сарын 12-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар уг асуудлыг хэлэлцүүлж, 378 дугаар тогтоолоор шийдвэрлүүлэв. Эрчимжүүлэх шаардлагатай 40 %</p>
<p>1.3.8.10. Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулах хүрээнд: 1.3.8.10.1. Нүүрсний нийлэг хийн үйлдвэрийн урьдчилсан болон нарийвчилсан ТЭЗҮ, БОННБҮ-г хүлээн авах</p>	<p>"Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төсөл"-ийн "Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ"-ний урьдчилсан төслийн тайланг 2018 оны 02 дугаар сард хүлээн авсан.</p> <p>Төслийн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээнд хяналт тавьж, эцсийн байдлаар хүлээн авах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд тус үнэлгээг хийж гүйцэтгэсэн бөгөөд Дэлхийн банк, "МИНИС" төсөл, гүйцэтгэгч "Грийн Трэндс" ХХК зэрэг оролцогч талууд холбогдох уулзалтуудыг зохион байгуулан ажиллаж байна. Төслийн БОННБҮ хүлээн авах хугацаа тодорхой хугацаагаар хойшлогдож байгаа гол шалтгаан нь Дэлхийн банк болон "МИНИС" төслийн шинжээч экспертүүд дотоод зохион байгуулалтын улмаас хэд хэдэн удаа солигдсонтой холбоотойгоор ажлын үнэлгээний явцыг дахин нягтлах, тайлагнах шаардлагатай болж ажлын явц удааширч байна. Үнэлгээг гүйцэтгэгч талаас төслийн БОННБҮ-ний тайлан эцсийн байдлаар бэлэн болгосон хүлээж байна. 2018 оны 02 сарын 20-нд Дэлхийн банк болон "МИНИС" төслийн холбогдох албаны хүмүүс Улаанбаатарт ирж ажлын явцыг дүгнэн ярилцах уулзалтыг хийхээр товлоод байна. Уулзалтын дараа нарийвчилсан үнэлгээний тайланг Дэлхийн банк, "МИНИС" төсөл, Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төслийн албан ёсны вэб сайтад байршуулах болно. Эрчимжүүлэх шаардлагатай 40 %</p>
<p>1.3.8.10.2. Үйлдвэрийн дэд бүтэц, барилгын ажлыг эхлүүлэх</p>	<p>БНХАУ-ын Үндэсний газрын тосны корпорац (CNPC)-ийн охин компани болох "Хуан Чү барилга угсралт, инженеринг" компани (HQC) болон "Хятадын газрын тосны шугам хоолой" компани (CPP)-ууд уг төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах сонирхлоо илэрхийлсэн.</p> <p>Төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтран ажиллахаар хүсэлт ирүүлсэн БНХАУ-ын аж ахуйн нэгжүүдтэй "Хамтран ажиллах санамж бичиг" байгуулахаар санамж бичгийн төсөл боловсруулаад байна.</p> <p>"Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн төслийн дамжуулах хоолойн трассыг тогтоох ажлын хүрээнд Төв аймгийн ИТХ-ын 2018 оны 01 сарын 12-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Хийг дамжуулах шугам хоолойн трассын байршлыг нарийвчлан тогтоож, хий дамжуулах хоолой дайран өнгөрөх газрыг Аймгийн тусгай хэрэгцээнд авсан.</p> <p>"Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн төслийн 2018 оны үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор "Улаанбаатар хотын байгалийн хийн түгээх шугам сүлжээний трасс, технологийн судалгаа" хийх зөвлөх үйлчилгээг үзүүлэх нээлттэй тендер 2 удаа зарлагдсан боловч ажлын даалгаврын шаардлага хангасан хуулийн этгээд оролцоогүй байна. Эрчимжүүлэх шаардлагатай 40 %</p>

<p>1.3.8.10.3. Үйлдвэрийн барилга угсралт болон боловсон хүчнийг сургах ажлыг зохион байгуулах</p>	<p>Төслийн хүрээнд төслийн нэгжийн ажилтнууд Нийслэлийн ЗДТГ болон Улаанбаатар хотын дүүргүүдтэй хамтран ажиллаж, хотын дулаан хангамжийн ерөнхий төлөвлөлттэй холбоотой баримт материал, зураг схемийг цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч, боловсруулан холбогдох урьдчилсан судалгааны ажлыг хийгээд байна. Мөн Нийслэлийн ЗДТГ-ын Хот төлөвлөлтийн газартай хамтран Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, дахин төлөвлөлтөд 2,3-р бүсийн айл өрхийн дулааны эх үүсвэрийг хийн түлшээр хангахад шаардагдах хийн түгээх шугам хоолойн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар уулзалт зохион байгуулж, холбогдох санал зөвлөмжийг авч дээрх судалгааны ажилд тусган ажиллаж байна.</p> <p>Төслийн нэгжээс олон улсын байгалийн хийн хэрэглээ, дамжуулах түгээхтэй холбоотой ISO, ГОСТ, CEN, ASTM, ANSI, API стандартуудыг судалж өөрийн орны онцлогт тохирох стандартуудыг сонгон авч, орчуулж байна. Орчуулж бэлтгэсэн стандартуудыг албажуулах асуудлаар СХЗГ-тай хамтран ажиллаж байна. Дараахь стандартуудыг орчуулж дуусгаад Техникийн хороогоор батлуулахад бэлэн болгов. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> •ГОСТ 3 56872-2016 Байгалийн хий. Нүүрстөрөгчийн давхар ислийг заагч хоолойгоор холбох •ГОСТ Р 56835-2015 Шингэрүүлсэн байгалийн хий. Хийн хроматографаар бүрэлдэхүүн хэсгийн бүтцийг тодорхойлох •ISO 15663-1 Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэл- Жилийн өртөгISO 12614-19 Авто тээврийн хэрэгсэл – Шингэрүүлсэн байгалийн хий (LNG) түлшний системийн бүрэлдэхүүн хэсгүүд •ISO 15500-7 Авто замын тээврийн хэрэгсэл- Шахсан байгалийн хий (ШаБХ) түлшний системийн эд анги, 7-р хэсэг: Хийн шүршигч зэрэг. Байгалийн хийн олон улсын стандарт, норм, дүрмийг үргэлжүүлэн орчуулж байна. Орчуулсан стандартуудыг хянан, эмхтгэж стандарт хэлжил зүйн газрын тос, байгалийн хийн техникийн хороогоор батлуулах ажлын хүрээнд стандарт тохируулгын газрын удирдлагуудтай уулзалт хийсэн. Уулзалтын үеэр орчуулгын явцтай танилцаж цаашид батлуулах боломжтой гэж үзсэн. <p style="text-align: right;">Эрчимжүүлэх шаардлагатай 40 %</p>
<p>2.2-р зорилтын хүрээнд: 2.2.1. Таван толгойн бүлэг ордыг ашиглах, Таван толгойн 450 МВт-ын цахилгаан станц, Гацууртын алтны орд, Дулааны III цахилгаан станцын 250 МВт-ын өргөтгөл, Чойбалсангийн ДЦС-ын 50 МВт-ын өргөтгөл зэрэг төслүүдийг хэрэгжүүлэх. 2.2.1.1. Тавантолгойн ордод түшиглэн олборлон баяжуулах үйлдвэрийн цогцолборыг барьж байгуулах хэлэлцээрийг эцэслэн гэрээг байгуулж, хөрөнгө оруулалт орж эхлэх нөхцөлийг бүрдүүлэх</p>	<p>“Таван толгойн нүүрсний ордыг иж бүрэн ашиглан үйл ажиллагааг эрчимжүүлэх, дагалдах дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх тухай” танилцуулга боловсруулж 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын зөвлөлийн хуралд танилцуулж тэмдэглэл гаргуулан хэрэгжүүлсэн.</p> <p>Тавантолгойн нүүрсний ордын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, холбогдох дэд бүтцийг барьж байгуулах зорилгоор “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 73 дугаар тогтоол гарч Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “б”, “в”-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Оюутолгой-Ханги, Тавантолгой-Барууннаран чиглэлийн авто замын төгсгөлөөс Цагаандэл уул чиглэлийн тусгай зориулалтын авто зам болон Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам зэрэг төслийг эхлүүлэх талаар шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон</p>

<p>СТРАТУУЛА</p>	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 104 дүгээр захирамжаар “Таван толгойн орд газрыг дэд бүтцийн хамт иж бүрнээр ашиглалтад оруулах талаар хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийж гэрээ байгуулах” ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар ахлуулан байгуулсан. Ажлын хэсгээс хөрөнгө оруулагчтай хийх хэлэлцээрүүд үргэлжилж байна. Тавантолгойн орд газраас 2016 оны эцсийн байдлаар 14.6 сая тонн нүүрс олборлож, 11.6 сая тонн нүүрс экспортолсон бол 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 18.5 сая тонн нүүрс олборлож, 16.9 сая тонн нүүрс экспортолсон. Улсын хэмжээнд 2018 оны 12 сарын 20-ны өдрийн байдлаар нийт 39,756.1 мянган тонн нүүрс олборлож, 35,371.8 мянган тонн нүүрс борлуулсан байна. Таван толгойн нүүрсний ордод өнөөгийн байдлаар төрийн өмчийн “Эрдэнэс Таван толгой” ХК, орон нутгийн өмч /51 хувь/-ийн оролцоотой “Таван толгой” ХК, хувийн хэвшлийн “Энержи Ресурс” ХХК үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тус ордоос 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 19,202.1 мянган тонн нүүрс экспортод гаргасан бол Нарийн сухайтын нүүрсний ордоос 13,573.7 мянган тонн нүүрс экспортод гарсан байна.</p> <p>Эрчимжүүлэх шаардлагатай 40 %</p>
<p>2.2.1.1. Гацууртын алтны үндсэн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар ахлуулсан Гацууртын орд газрын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй Хөрөнгө оруулалтын болон Орд ашиглах гэрээ байгуулах талаар хэлэлцээр хийх Ажлын хэсгийг Ерөнхий сайдын захирамжаар байгуулаад байна. Монгол улсын ерөнхий сайдын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 20 дугаар захирамжаар Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах талаар хэлэлцээ хийх, 21 дүгээр захирамжаар Орд ашиглах гэрээ байгуулах ажлыг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгүүдийг тус тус байгуулсан. УУХУ-ийн сайдын 2017 оны А/28 дугаар тушаалаар Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардагдах баримт бичгийн төслийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг байгуулагдсан ба “Орд ашиглах гэрээ”-ний төслийг боловсруулж, 2017 оны 03 дугаар сарын 01-ний өдөр төсөлд санал авахаар “Сентеррагоулд Монголия” ХХК-нд хүргүүлсэн. Мөн Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Үндэсний хөгжлийн газраас байгуулсан Ажлын хэсэг боловсруулж, “Сентеррагоулд Монголия” ХХК-иас санал авахаар 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн. Шинжээчдийн дүгнэлт гарч, нөөц тодорхой болсон тохиолдолд гэрээний хэлэлцээрийг үргэлжлүүлэхээр хүлээж байна.</p> <p>Эрчимжүүлэх шаардлагатай 40 %</p>
<p>2.3-р зорилтын хүрээнд: 2.3.8. Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг мэргэшсэн, хариуцлагатай, цомхон, тогтвортой байх эрх зүйн орчныг бүрдүүлэх. 2.3.8.2. Чиг үүргийн шинжилгээнд үндэслэн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай Засгийн газрын 370 дугаар тогтоол батлагдсан. Үүнтэй холбогдуулан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 23 дугаар зүйлд тодорхой заасны дагуу мэргэжил, мэргэшил, төрийн алба хаасан хугацааг шалгуур үзүүлэлт болгон сонгон шалгаж, томилгоог хийсэн.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай” 02 дугаар тогтоолын 1-7 дугаар хавсралтуудаар баталсан. Батлагдсан шаардлагын дагуу “Албан тушаалын тодорхойлолт” /АТТ/ боловсруулах ажлын хэсгийг ТНБД-ын 2019 оны А/52 дугаар тушаалаар байгуулан, 2019 оны 5 дугаар сард багтаан АТТ-ыг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.</p> <p>Тодорхой үр дүнд хүрсэн 70%</p>

7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>ДҮГНЭЛТ</p> <p>1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжсэн "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-ийн 4 зорилтын 24 арга хэмжээний биелэлт нь 2018 оны жилийн эцсийн байдлаар 55.7 хувьтай дүгнэгдсэн.</p> <p>2. Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлж, ойрын хугацаанд төлөх гадаад өр төлбөрийг санхүүжүүлэх үүсвэрийг шийдвэрлэх зорилтын хүрээнд Алт хөтөлбөрийг шинэчлэн үргэлжлүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангалттай сайн гүйцэтгэн ажилласан.</p> <p>3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах хоолойн барилгын ажлын зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг эхлүүлэх, уулын баяжуулах үйлдвэрүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах буюу хүнд үйлдвэрийг барьж байгуулах, бүтээн байгуулалтын ажлыг бодитоор эхлүүлэх ажлууд удаашралтай хэрэгжиж байна.</p> <p>4. Хөтөлбөрт тусгагдсан бусад байгууллагуудтай тус яамны "хамтран" хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг хариуцсан нэгж, албан хаагчид хяналтандаа авч, хэрэгжилтийн үр дүнг тайлагнах талаар анхаарахгүй, орхигдуулсан.</p> <p>5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний шаардагдах хөрөнгийн талаар биелэлтэндээ дурдаагүй, хүрсэн үр дүнг шалгуур үзүүлэлттэй холбон тайлагнах талаар хангалтгүй ажиллаж байна.</p> <p>6. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны асуудал хариуцсан мэргэжлийн нэгжүүд болон нийтлэг чиг үүрэгтэй төрийн захиргааны удирдлагын нэгжийн албан хаагчид нь хариуцсан асуудлаар боловсруулсан бодлого, төлөвлөлтийг холбогдох бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах, хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хяналтандаа авах, хэрэгжилтийн үр дүнд анхаарах, биелэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоосон хугацаанд товч тодорхой тайлагнах, дэлгэрэнгүй тайланг танилцуулга хэлбэрээр, холбогдох нотлох баримтуудын хамт хавсаргах талаар хариуцлагатай, санаачлагатай ажиллахгүй байна.</p> <p>САНАЛ, ЗӨВЛӨМЖ</p> <p>1. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны асуудал хариуцсан мэргэжлийн нэгжийн удирдлага, албан хаагчид нь чиг үүрэг, хариуцсан асуудлаар боловсруулж байгаа бодлого, төлөвлөлт болон бодлогын баримт бичгийн биелэлтийг тайлагнахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна.</p> <p>2. Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт тусгагдсан 24 арга хэмжээний эрчимжүүлэх шаардлагатай 14 арга хэмжээ, үнэлэх боломжгүй 1 арга хэмжээний хэрэгжилтэнд анхаарч, бодитой үр дүнд хүргэхэд чиглэн ажиллах шаардлагатай байна.</p>
---	---	---

8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Захиалагч талууд, хэрэгжүүлэгч талууд, санхүүжүүлэгч тал, гүйцэтгэгч талууд хэрхэн хамтарч ажилласан талаар энд бичнэ.					
9	Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (УУХҮЯ-ны үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилт 1.1	Зорилт 1.3	Зорилт 1.3	Зорилт 2.2	Зорилт 2.3
		55.70%	70%	90%	49.4%	40%	70%
10	Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ					
	(ЗГХЭГ-ын үнэлгээ)	... %					

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Хянасан: ХШУДАГ-ын дарга

Г.Ганхүү

Биелэлтийг нэгтгэж, ХШҮ хийсэн: ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн

Н.Баатар /2019.03.28/

Н.Баатар
2019.03.28